



ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ТӨМӨРБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А.128


Төмөрбулаг сум

Г Мал амьтны сэг зэм устгал, ариутгал Т халдваргүйтгэлийн ажил, зэрлэг амьтанд өвс тэжээл бэлтгэх ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3, 7 дугаар зүйлийн 7.3.2, 7.3.3, 7.3.6, 28 дугаар зүйлийн 28.4, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 02,04 дүгээр албан даалгавар, Гамшгаас хамгаалах тухай зүйлийн 20 дугаар зүйлийн 20.1, Амьтны тухай хуулийн 5.5, 5.5.1, 5.7, 5.7.1, 6 дугаар зүйлийн 6.1.8, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны А/40 дугаар тушаал, Аймгийн засаг даргын 2024 оны 03 сарын 25-ны өдрийн А/122 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын хэмжээнд зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, булшлах, орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн ажлыг 2024 оны 03 сарын 28-ны өдрөөс 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор сумын хэмжээнд зохион байгуулж ажиллахыг ХАА тасгийн мэргэжилтэн /Д.Сайнбаяр/, байгаль орчин, онцгой байдал хариуцсан мэргэжилтэн Д.Хишигсайхан, мал эмнэлгийн тасгийн мэргэжилтэн /Э.Мөнгөнзагас/ нарт үүрэг болгосугай.
2. Орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн ажлын хэсгийн гишүүдийг нэгдүгээр хавсралтаар, ховор амьтныг хамгаалах биотехникийн арга хэжээ авах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар, Мал амьтны сэг зэмийг цуглуулж устгах төсвийг гуравдугаар хавсралтаар, ховор ан амьтныг хамгаалах биотехникийн арга хэмжээний төсвийг дөрөвдүгээр хавсралтаар баталсугай.
3. Зэрлэг ан амьтанд өвс тэжээл бэлтгэх ажлыг зохион байгуулахыг сумын засаг даргын орлогч /Ч.Энхбаяр/-т үүрэг болгосугай.
4. Сэг зэм цуглуулах, устгах, ариутгал халдваргүйтгэлийн ажлыг эрс сайжруулан ажиллахыг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт, мэргэжил арга зүй, удирдлагаар ханган хяналт тавьж, холбогдох мэдээ тайланг гаргаж хугацаанд нь хүргүүлж ажиллахыг мал эмнэлгийн тасгийн мэргэжилтэнд үүрэг болгосугай.
5. Ариутгал халдваргүйтгэл болон шатахуун, шааардагдах бусад зардлыг зарцуулан ажиллахыг Засаг даргын тамгын газрын нягтлан бодогч /Х.Даваачулуун/-д зөвшөөрсүгэй.
6. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг тамгын газрын дарга /Г.Нямханд/-д үүрэг болгосугай.

ДАРГА



А.МӨНХ-ЭРДЭНЭ